



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар Б/БЗ

Улаанбаатар хот

О.Нямдоржид цалинтай чөлөө,  
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.16, 7.3.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Эрхзүйч Очирхуягийн Нямдоржийн өвөг эцэг таалал төгссөн тул 2020 оны 07 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд цалинтай чөлөө, нэг удаагийн буцалтгүй тусламж 200,000 төгрөг /хоёр зуун мянга/-ийг тус тус олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн зардлыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. О.Нямдоржийн албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга, Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР